

2023 оны “Төсвийн тухай хууль”-ийг дагалдан өргөн барьсан татварын хуулийн өөрчлөлтүүд

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
Enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhvanaa.erdene-ochir@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Засгийн Газраас Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт Улсын Их Хуралд өргөн барьсан. Тус 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих болон төсвийн орлогын шинэ их үүсвэр бий болгоход чиглэсэн зарчмуудыг баримталсан байна. Бид энэхүү татвар болон хууль эрх зүйн мэдээллээрээ төсвийн хуулийг дагалдуулан татварын хуулиудад оруулахаар санал болгож буй гол өөрчлөлтүүдээс та бүхэнд танилцуулж байна.

Хувь хүний орлогын албан татвар (“ХХОАТ”)-ын тухай хуульд:

Олон улсын нийтлэг туршлагад үндэслэн, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгоор 2023 оноос эхлэн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогод “шаталсан хувиар” ХХОАТ ногдуулах саналыг Сангийн яамнаас гаргажээ. Хуулийн өөрчлөлт нь нийт цалингийн орлого бүхий иргэдийн 0.1 хувьд нөлөөлөхөөр байна гэж хуулийн төслийн танилцуулгад дурдсан байна.



Хэрхэн өөрчлөгдөх вэ?

ХХОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын жилийн татвар ногдуулах орлогын дүнд дараах хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

Жилийн орлого (₮)	Татварын хэмжээ (%)
0-120 сая	10%
120 сая -180 сая	12 сая төгрөг дээр нэмэх нь 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15%
180 сая төгрөгөөс дээш	21 сая төгрөг дээр нэмэх нь 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20%

Суутгагч цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын татвар ногдуулалт, хөнгөлөлтийг тооцоог жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлэхээр хуулийн төсөлд мөн тусгасан байна.




Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (“ААНОАТ”)-ын хуульд:

1. Гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд арилжаалагдах үнэт цаас гаргах компаниудын хувьд (ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй компаниудад хамаарахгүй):

- Хувьцааны ногдол ашгийн суутган татварыг 5 хувь болгох;
- Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбогдон гарсан зардлыг 20 хувиар өсгөж тооцон татвар ногдох орлогоос хасаж тооцохыг зөвшөөрөх.





2. Хөрөнгө оруулалтын сангууд:

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг татвараас чөлөөлөх. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд “Хөрөнгө оруулалтын сан”-г хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар тодорхой үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн сан гэж тодорхойлсон. Одоогоор 36 Хөрөнгө оруулалтын сан Монгол улсад үйл ажиллагаа явуулж байна.

3. Гарааны компаниудын хувьд:

Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 3 жилийн хугацаанд бүрэн хөнгөлөлт үзүүлж байгааг 5 жил болгож сунгах.



4. IT компаниудын хувьд:

Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг оршин суугч татвар төлөгчийн өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн эрхийн шимтгэл, сервер түрээслэх төлбөртэй холбоотойгоор оршин суугч бус татвар төлөгчид шилжүүлсэн орлогод ногдуулах албан татварын хувь хэмжээг 5 хувиар болгож бууруулах.

5. Нийтийн тээврээр зорчих тасалбар, эсхүл зорчих эрхийг бэлэн бусаар ажилтандаа олгосон компаниудын хувьд :

Тухайн тасалбар, зорчих эрхийг худалдан авсантай холбогдон гарсан, хасагдах зардлын ерөнхий ба тусгай шаардлагуудыг хангасан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж тооцон тооцон татвар ногдох орлогоос хасаж тооцохыг зөвшөөрөх.



Та дээрх сэдэв болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол бидэнтэй холбоо барина уу.

Төсвийн тухай” хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [энд дарна уу](#).

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.